210604	Урсгал засвар	17,599,700.00	17,513,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,702,900.00</b>	<b>8,376,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	10,702,900.00	8,376,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,049,200.00</b>	<b>8,502,736.00</b>

**Өндөрхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,853,400.00	2,524,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,066,400.00	1,879,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	639,000.00	461,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	537,900.00	220,274.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,761,300.00	2,378,500.00
210807	Газрын төлбөр	971,200.00	917,712.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>77,603,300.00</b>	<b>70,755,160.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,270,400.00	60,896,410.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,332,900.00	9,858,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,702,400.00</b>	<b>46,626,145.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,702,400.00</b>	<b>46,626,145.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,064,700.00	42,061,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,637,700.00	4,564,425.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>247,135,300.00</b>	<b>194,259,980.00</b>
223001	Бусад хөрөнгө	247,135,300.00	194,259,980.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>239,958,900.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	239,958,900.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,304,189,800.00</b>	<b>3,032,579,594.81</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,032,565,800.00</b>	<b>1,999,009,626.38</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,851,683,900.00	1,818,127,747.38
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	180,881,900.00	180,881,879.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>893,141,700.00</b>	<b>859,512,229.43</b>
320001	Орон нутгийн төсвөөс	893,141,700.00	859,512,229.43
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>59,520,000.00</b>	<b>56,943,930.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	59,520,000.00	56,943,930.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>318,962,300.00</b>	<b>117,113,809.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,200,000.00	88,113,809.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	29,000,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	162,762,300.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	184,001,340.38
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	278,497,564.61
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,182.00</b>	<b>1,182.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>
610001	Төсвийн байгууллага	7.00	7.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>155.00</b>	<b>155.00</b>
620001	Удирдах ажилтан	14.00	14.00
620002	Гүйцэтгэх ажилтан	97.00	97.00
620003	Үйлчлэх ажилтан	31.00	31.00
620004	Гэрээт ажилтан	13.00	13.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>865.00</b>	<b>865.00</b>

<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>676.00</b>	<b>676.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	676.00	676.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>189.00</b>	<b>189.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	189.00	189.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>155.00</b>	<b>155.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0.00	0.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	0.00	0.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	61.00	61.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	23.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38.00	38.00
650010	Гэрээт ажилтан	11.00	11.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>236,941,154.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>187,441,154.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>133,348,154.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>40,660,028.00</b>
210101	Үндсэн цалин	26,135,437.00
210102	Нэмэгдэл	14,524,591.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,169,941.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,169,941.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,914,342.00</b>
210401	Бичиг хэрэг	1,326,542.00
210402	Тээвэр, шатахуун	8,727,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,460,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,015,431.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,359,231.00
210502	Хоол, хүнс	2,656,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,280,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,280,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,552,812.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	852,812.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,755,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,150,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,605,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,093,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>52,610,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,610,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,483,000.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,483,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>49,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>49,500,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	49,500,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>236,941,154.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>236,941,154.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,591,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,896,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,265,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,189,154.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Өндөрхангай сумын Засаг дарга нь *Иргэдийн амьдрах эрүүл тав тухтай, аюулгүй орчин бий болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар өрхийн орлого нэмэгдүүлсэн ШИНЭ-ӨНДӨРХАНГАЙ* гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Цар тахлаас урьдчилан сэргийлэх
- Түүх, ёс заншлаа сэргээн хамгаалах, түгээн дэлгэрүүлэх замаар нийгмийг соён гэгээрүүлэх
- Боловсролын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эрүүл идэвхтэй амьдралын хэвшлийг дэлгэрүүлэх
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Ажлын байр, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх
- Иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
- Орчны бохирдлыг бууруулах
- Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглалтыг дэмжих зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсээс Өндөрхангай сумын төрийн сангийн 2021 оны эхний хагас жилийн баримтыг татан авч 4 бүлэг 6 асуудлаар хяналт шалгалт хийж 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна. Өндөрхангай сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 26.6 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,332.0 сая төгрөгийн 1 хувь буюу 33.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 26.6 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өндөрхангай сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,773.6 сая төгрөгөөр буюу 35.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая.төгрөг/		
Мөнгөн хөрөнгө	308.4	545.2	236.8
Авлага	191.9	272.0	80.1
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	184.3	225.3	41.0
Үндсэн хөрөнгө	4,372.2	5,787.9	1,415.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,056.9</b>	<b>6,830.5</b>	<b>1,773.6</b>
Нийт өр төлбөр	12.3	33.9	21.6
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,044.6	6,796.6	1,752.0
Засгийн газрын хувь оролцоо	5,044.6	6,796.6	1,752.0
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,056.9</b>	<b>6,830.5</b>	<b>1,773.6</b>

Эх сурвалж: Өндөрхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 545.2 сая төгрөг болж 236.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

#### Аудитын илрүүлэлт:

##### Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар:

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, бараа үйлчилгээний бусад зардал, шуудан холбоо, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг шууд зардалд бүртгэсэн 91.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа.

##### Өндөрхангай сумын Соёлын төв:

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг шууд зардалд бүртгэсэн 0.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 272.0 сая төгрөг болж 80.1 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

#### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 225.3 сая төгрөг болж 41.0 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн цэцэрлэг, Сум дундын ойн анги, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,787.9 сая төгрөг болж 1,415.7 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс бэлтгэсэн үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

##### **Өндөрхангай сумын Хүүхдийн цэцэрлэг:**

- Санхүүгийн тайланд 736.8 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилгыг үндсэн хөрөнгийн дансанд тусгаагүй байсныг залрууллаа.

### 3.5.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 33.9 сая төгрөг болж 21.6 сая төгрөгөөр өссөн Сум дундын эмнэлгийн тайлан нэгтгэсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

##### **Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар:**

-Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийг зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 6.4.8 дахь заалтад "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчин 2020 онд Өндөрхангай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн баруун голын гүүрний засварын үлдэгдэл 4.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт дансанд төвлөрүүлснийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн боловч гүйцэтгэгч компанид өгөх өглөг бүртгээгүй байна. Тайлант онд санхүүгийн тайланд тусгаагүй дээрх өглөгийг гүйцэтгэгч компанид шилжүүлсэн зөрчилд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр" заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,796.6 сая төгрөг болж 1,752.0 сая төгрөгөөр буюу 34.7 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,403.6 сая төгрөгөөр буюу 41.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 13.9 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 1.4 сая төгрөгөөр хийгдсэн байна.

### 3.5.6 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 311.8 сая, татварын бус орлого 341.0 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,230.2 сая, нийт 3,883.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.5.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 6.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

##### **Өндөрхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 0.5 сая төгрөгийн 235 л бензинийг ямар ажлаар явсан нь тодорхойгүй, замын хуудасгүй, хийсэн ажлын тайлангүйгээр зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

##### **Өндөрхангай сумын Ерөнхий боловсролын сургууль:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалтад "Бүх зардал" гэж заасныг зөрчин 2019 оны санхүүгийн тайланд хоолны зарлагыг 5,684.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдааг Санхүү хяналт аудитын албаны тогтоосон акт, хоолны зардлын түүврийг үндэслэн 2021 оны санхүүгийн тайланд 5.6 сая төгрөгийн хоол хүнсний зардлыг бүртгэж залрууллаа.

##### **Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төв:**

- Суутган тооцоогүй цалингийн урьдчилгааны 0.3 сая төгрөгийг зардалд бүртгэсэн байсныг санхүүгийн тайланд авлага тусгуулан залрууллаа.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өндөрхангай сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/05 дугаар тогтоолоор 3,193.4 сая төгрөгөөр баталж 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 4/05 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 110.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,304.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,304.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,851.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 893.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 180.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 59.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 156.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 162.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,818.1 сая, орон нутгийн төсвөөс 859.5 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 180.8 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 56.9 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 88.1 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 29.0 сая, нийт 3,032.5 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 2,938.1 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 55.4 сая, улсын төсөвт 33.5 сая, нийт 88.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Тайланд онд улсын төсвөөс 33.5 сая, орон нутгийн төсвөөс 33.6 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 2.5 сая, үйл ажиллагааны орлогоос 201.8 сая, нийт 271.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,938.1 сая төгрөг буюу 88.9 хувьтай байна.

Өндөрхангай сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 05/01 дүгээр тогтоолд зааснаар Өндөрхангай сумын Засаг дарга тайлант онд 69.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 362.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 523.5 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 58.3 сая, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 13.9 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 16.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 148.1 сая, нийт 236.9 төгрөгийн орлогыг бүрдүүлж 236.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Өндөрхангай сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 151, хугацаа хоцроож мэдээлсэн 4 мэдээлэл байна. Мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.3 сая төгрөгийн акт тогтоосныг Өндөрхангай сумын Цэцэрлэгийн 2021.05.13-ны 08 албан бичиг, холбогдох баримтын хамт биелэлтийг ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ЗДТГ нь Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна.

Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 119,987.7 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна.

Сумын ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг тус тус дараагийн аудитын хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Өндөрхангай сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 7 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 838.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 834.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	1	0.5					1	0.5		
2	ЗДТГ	2	95.5	1	91.5					1	4.0
3	ЕБС	1	5.6	1	5.6						
4	ЭМТ	1	0.2	1	0.2						
5	Цэцэрлэг	1	736.8	1	736.8						
6	Соёлын төв	1	0.3	1	0.3						
<b>Дүн</b>		<b>8</b>	<b>838.9</b>	<b>5</b>	<b>834.4</b>			<b>1</b>	<b>0.5</b>	<b>1</b>	<b>4.0</b>

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.2 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчин сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан зөөврийн байрыг 0.2 сая төгрөгөөр данс бүртгэлд дутуу бүртгэснийг аудитын явцад залрууллаа.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өндөрхангай сумын Засаг дарга	1	0.2	1	0.2						
<b>НИЙТ</b>		1	0.2	1	0.2						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

/Т.АМАРМЭНД/

2022 оны 03 сарын 23-ны өдөр